

Цалинг хэрхэн бодож олгодог вэ

Сайн байна уу!

Та бүхэнд ажилтны сарын цалинг ямар хууль тогтоомж, эрх зүйн акт баримтлан хэрхэн бодож олгодогийг дор жишээ татан үзүүлэхээр бэлтгэв.

Юуны түрүүнд Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний /ТҮШУ/ албан тушаал болон төрийн үйлчилгээний /ТҮ/ албан тушаалтны цалингийн сүлжээг хүснэгтээр харуулья.

1. **Үндсэн цалин:** /Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 2-р хавсралт, 2014 оны 75 дугаар тогтоолыг тус тус баримтлана./

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл /төгрөг/						
	ТҮШУ-1	ТҮШУ-2	ТҮШУ-3	ТҮШУ-4	ТҮШУ-5	ТҮШУ-6	ТҮШУ-7
1	496912	622878	673849	718985	767451	819795	876325
2	500784	628022	679507	726044	773994	826859	883954
3	510623	641091	693884	740341	790516	844704	903227
4	535584	674244	713968				
5	563430	711230	734053				

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл /төгрөг/						
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7
1	371016	388317	402075	416521	446857	496912	535286
2	373591	391094	404991	419582	450224	500784	539547
3	380041	398148	412398	427360	458780	510623	550369
4	396798	416046	431190	447091	480485	535584	577826
5	415496	436012	452155	469105	504699	563430	608457

2. **Зэрэг, цолны нэмэгдэл:** /Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол/
 - Доктор үндсэн цалингийн 20%
 - Дэд доктор үндсэн цалингийн 15%
 - Профессор үндсэн цалингийн 10%
 - Дэд профессор үндсэн цалингийн 5%
3. **Зэрэг дэвийн нэмэгдэл:** /Засгийн газрын 2012 оны 2-р сарын 15-ны өдрийн 50 дугаар тогтоол/
 - Тэргүүлэх ажилтан үндсэн цалингийн 20%
 - Ахлах ажилтан үндсэн цалингийн 15%
 - Дэд ажилтан үндсэн цалингийн 10%
4. **Унаа хоолны нэмэгдэл:** /Тодорхой гарсан хууль эрх зүйн акт байхгүй/
2012 оны төсөвт нэг хүнд тооцох унааны нэмэгдлийг өдөрт 400.00 төгрөг, хоолны нэмэгдлийг 1000.00 төгрөгөөр тусгаж оруулсан буюу сард /22 хоног/ нийт унаа хоолны нэмэгдлийг 30,800.00 төгрөгөөр тооцож байна.

Жишээ: Та ТҮШУ-3-5 шатлалаар цалинждаг буюу сарын үндсэн цалин 734,053.00 төгрөг, дэд доктор зэрэгтэй, профессор цолтой, эрдэм шинжилгээний дэд ажилтан гэвэл таны сарын цалинг дор бодож үзүүлье.

2014 оны 9-р сар ажлын 22 хоногтой, та нэг өдөр чөлөө авч, 21 хоног ажилласан гэж үзвэл:

Сарын үндсэн цалин /ҮЦ/ : $734,053.00 / 22 \text{ хоног} \times 21 \text{ хоног} = 700,686.95$ төгрөг

Зэрэг цолны нэмэгдэл /ЗЦН/ : $700,686.95 \times (15\%+10\%) = 175,171.74$ төгрөг

Зэрэг дэвийн нэмэгдэл /ЗДН/ : $700,686.95 \times 10\% = 70,068.70$ төгрөг

Унаа хоолны нэмэгдэл /УХН/ : $21 \times (400.00+1000.00)=29,400.00$ төгрөг

ҮЦ+ЗЦН+ЗДН+УХН= Нийт бодогдсон цалин

$700,686.95+175,171.74+70,068.70+29,400.00=975,327.39$ төгрөг болно үүнээс суутгах татваруудыг дор үзүүлье.

Суутгалууд тооцох:

Нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/ бодох:

Ажил олгогч буюу байгууллагаас төлөх дүн:

$975,327.39 \times 11\%=107,286.01$ төгрөгийг байгууллага улсын төсвөөс батлагдсан цалингийн сангаас Нийгмийн даатгалын санд төлнө.

Хувь хүнээс буюу даатгуулагчаас суутгах дүн:

$975,327.39 \times 10\%=97,532.74$ төгрөгийг танд бодогдсон 975,327.39 төгрөгийн цалингаас суутгаж байгууллага Нийгмийн даатгалын санд шилжүүлнэ.

/жич: ЗГ-ын 1998 оны 6-р сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна гэж заасан. Энэ нь та 1,920,000.00 төгрөгөөс дээш хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй зөвхөн 1,920,000.00 төгрөгний орлогод 10 хувиар тооцож шимтгэл төлнө. Жишээ нь: та 2,500,000.00 төгрөгний цалин авдаг бол 1,920,000.00 төгрөгний орлогод ногдох шимтгэл 192,000.00 төгрөгийг танаас суутгана, харин $2,500,000.00-1,920,000.00 = 580,000.00$ төгрөгийн орлогоос шимтгэл тооцож суутгахгүй юм.

Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/ тооцох: Нийт бодогдсон цалингаас НДШ-ийг хассан дүнгээс ХХОАТ-ыг 10 хувиар бодно.

$975,327.39 / \text{Бүгд цалин} / - 97,532.74 / \text{НДШ} / = 877,794.65$ төгрөг ХХОАТ-ыг тооцох цалингийн дүн.

$877,794.65 \times 10\%=87,779.46$ суутгах татварын хэмжээ.

Дээр бодсон суутгах татварын дүнгээс “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24-р зүйлийн 1 –д заасан хөнгөлөлт болох жилийн 84,000.00 төгрөг буюу сарын 7,000.00 төгрөгийн /84,000.00 : 12 сар/ татварын хөнгөлөлтийг хасна. Өөрөөр хэлбэл энэ хуулийн дагуу таны сарын цалингийн 70,000.00 төгрөгийн орлогод ногдох $70,000.00 \times 10\% =$

7,000.00 төгрөгийг хөнгөлж байна гэж ойлгож болно. /энэ хөнгөлөлтийг сард нэг удаа үзүүлэх буюу бусад эх үүсвэрээс орсон орлогоос давхардуулан хөнгөлөхгүй/

$87,779.46 - 7,000.00 = 80,779.46$ төгрөг ХХОАТ-т суутгах цэвэр дүн.

Ингээд таны нийт цалингаас суутгах дүн:

97,532.74 /НДШ/ + 80,779.46 /ХХОАТ/=178,312.20 төгрөг

Таны гарт олгох цалин: 975,327.39-178,312.20=797,015.18 төгрөг таны гар дээр очно.

Дор хүснэгтэнд дээрх тооцооллыг бодож гаргав. Мөн 2-р мөрөнд хэрэв та бүтэн 22 хоног ажилласан үед таны цалинд хэрхэн өөрчлөлт орж байгааг харуулав.

Д/Д	Нэр	Үндсэн цалин	Ажлын хонгог	Ажилласан хонгог	Бодогдсон цалин	Зэрэг, цолны нэмэгдэл	Зэрэг дэвийн нэмэгдэл	Унаа, хоолны нэмэгдэл	Нийт бодогдсон цалин	Суутгал		Нийт суутгалын дүн	Гарт олгох дүн
										НДШ /Даатгуулагчаас суутгах/	ХХОАТ		
1	2	3	4	5	6=3/4*5	7=6*... хувь	8=6*... хувь	9	10=6+7+8+9	11=10*10%	12=(10-11)*0.1-7000	13=11+12	14=10-13
1	Бат	734,053.00	22	21	700,686.95	175,171.74	70,068.70	29,400.00	975,327.39	97,532.74	80,779.46	178,312.20	797,015.18
2		734,053.00	22	22	734,053.00	183,513.25	73,405.30	30,800.00	1,021,771.55	102,177.16	84,959.44	187,136.59	834,634.96*
3	Наран	2,500,000.00	22	22	2,500,000.00	-	-	-	2,500,000.00	192,000.00	223,800.00	415,800.00	2,084,200.00

Тайлбар: Танд 834,6* мянган төгрөгийн цалин олгохын тулд улсын төсөвт сард 1,021.8 мянган төгрөгийг цалингийн зардалд, 112.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, нийлээд цалингийн санд 1,134.2 мянган төгрөг тусгадаг бөгөөд үүнийг жилээр тооцвол танд 10,015.2 мянган төгрөгийн цалин олгохын тулд цалингийн санд 13,610.0 мянган төгрөг тусгаж, үүнээс татвар, даатгалд нийт 3,594.8 мянган төгрөг төлдөг бөгөөд үүний 1,348.7 мянган төгрөгийн НДШ-ийг байгууллагаас, 2,246.1 мянган төгрөгийн татвар, даатгалыг та өөрийн орлогоос төлдөг байна.

Мэдээлэл: Улиралд нэг удаа таны цалингийн мэдээллийг дараа сарын 20- ны дотор өөрийн хаяг руу тань явуулах болсныг мэдэгдье.

ООГСТ-ийн Санхүү 2014 он